



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 07 сарын 29 өдөр

Дугаар Е/07

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Оюутолгой ордод холбогдох ноцтой баримт, мэдээллүүд, хууль, шүүхийн байгууллагын явуулж буй үйл ажиллагааны талаар дотоодод төдийгүй гадаадад цацагдаж, иргэд олон нийтийн анхаарлыг татсан гол асуудал болж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн өлсгөлөн зарлаж, амь нас, эрүүл мэндээ хүртэл эрсдэлд оруулахад хүрч буй энэхүү асуудал улам даамжирч, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагын хүрээнд эсэргүүцэл, тэмцэл хүндрэх нөхцөл үүсээд байхад Улсын Их Хурал анхаарч, арга хэмжээ авахгүй байгаад миний бие шүүмжлэлтэй хандаж байна.

Оюутолгой бол улс орны хөгжил, аюулгүй байдалтай шууд холбогдох томоохон төсөл тул үүсээд байгаа асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн эрх барих дээд байгууллагын түвшинд тодорхой чиглэл, шийдвэр гаргах зайлшгүй шаардлагатай юм.

Үүний хүрээнд Улсын Их Хурал Оюутолгойн асуудлыг тойрсон авлига, албан тушаалын гэмт хэрэг, Монгол Улсын эрх ашгийг хамгаалах, хангуулах асуудлын хүрээнд хаалттай хуралдаан зохион байгуулж, хууль, хяналтын байгууллагын мэдээллийг сонсох, Улсын Их Хурлын гишүүд нэгдсэн байр суурь ойлголттой болох хэрэгтэй байна.

Иймд Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулган завсарлахаас өмнө уг асуудлаар хаалттай хуралдаан зохион байгуулахыг санал болгож байна.

Зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

2021000029